



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 02 өдөр

Дугаар Д/К 28

Хэрлэн сум

Үнэлгээний хороо
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн болон Япон улсын элчин сайдын яамны Өвсний үндэс төслийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжих Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гүйлтийн зам, хөл бөмбөгийн талбайн ус зайлуулах суваг (Хэрлэн сум), Батширээт сумын эрүүл мэндийн төвийн засвар ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны
дарга:

Г.Лхагвахатан

Орон нутгийн өмчийн
газрын дарга

Нарийн бичгийн
дарга:

Ц.Мягмар-Ариунаа

Орон нутгийн өмчийн
газрын худалдан авах
ажиллагаа хариуцсан
мэргэжилтэн

Гишүүд:

М.Хишигбаяр

Газрын харилцаа,
барилга хот
байгуулалтын хэлтсийн
дарга

Х.Гонгор

Иргэний төлөөлөл

Д.Оюун

Төрийн бус
байгууллагын төлөөлөл

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Г.Лхагвахатан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.НОГСОМЖАВ